



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,099,200.00 (гурван сая ерэн есөн мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ (Р.Амартүвшин)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн нийт 3,099,200.00 (гурван сая ерэн есөн мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ (Р.Амартүвшин)-т татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэст даалгасугай.

ДАРГА *В. Оюунмаа* ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 09 дугаар сарын 11-ны өдрийн А/187 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагу н үнийн санал	НӨХГ-ын мөргөжлтийн дүгнэлт	ЭБХХК-ийн шийдвэр
Тавилга, эд хогшил													
1	Сандаг /уулзалт/	10	ш	1	184,200.00	184,200.00	184,200.00	-	Ашиглах боломжгүй	актлах	-	татах	татах
2	Сандаг /нуруу амраагчт ай/	5	ш	1	200,000.00	200,000.00	200,000.00		Ашиглах боломжгүй	актлах	-	татах	татах
3	Сандаг /нуруу тохой амраагчт ай/	5	ш	1	240,000.00	240,000.00	240,000.00		Ашиглах боломжгүй	актлах	-	татах	татах
							624,200.00						
Компьютер тоног төхөөрөмж													
1	Принтер /L1455/	5	ш	1	2,475,000.00	2,475,000.00	2,475,000.00		Ашиглах боломжгүй	актлах	-	татах	татах
Тоног төхөөрөмжийн дүн													
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн													
Үүнээс. Худалдах хөрөнгө													
Устгах хөрөнгө													
Татан төвлөрүүлэх хөрөнгө													
Худалдсанаас олох орлого													
НӨХГ-г төвлөрүүлэх /30%/													